


БАТЛАВ.  
“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”  
ОНӨТҮГАЗАР

ДАРГА  БАТЖАРГАЛ/




**“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”  
ОНӨТҮГ-ЫН АЖИЛЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ  
ХАНГАХ ТУХАЙ ХӨТӨЛБӨР**

/2019 ОН/

БОЛОВСРУУЛСАН:

Хүний нөөцийн мэргэжилтэн

 Э.Энгүүн

ХЯНАСАН:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга  Ц.Бямбасүрэн

## **АГУУЛГА**

### **1. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн нийтлэг үндэслэл**

- 1.1. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зорилго
- 1.2. Хөтөлбөрийн эрхзүйн үндэс
- 1.3. Хөтөлбөрийн хэрэгцээ

### **2. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн удирдлага**

- 2.1. Ажилчдын одоогийн нөхцөл байдал
- 2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам
- 2.3. Хэрэгжилтэд тавих хяналт

### **3. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хамрах хүрээ**

- 3.1. Төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа ба түүний тасралтгүй хөгжлийг хангах
- 3.2. Ажилчдын цалин хөлс, урамшууллын уян хатан, ил тод, шударга тогтолцоог бүрдүүлэх
- 3.3. Ажилчдын хэрэгцээнд үндэслэн орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, нөхцлийг нь сайжруулахад дэмжлэг үзүүлэх
- 3.4. Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажилчдын нийгмийн баталгааг сайжруулах
- 3.5. Ажилчдын осол гэмтэлгүй, ая тухтай, бие сэтгэлзүйн ямар нэг дарамт, шахалтгүй ажиллах эерэг таатай орчинг бүрдүүлж, ажлын бүтээмж, гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- 3.6. Ажилчдыг чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх, хамт олны тааламжтай, сэтгэлзүйн эрүүл орчин бүрдүүлэх

### **4. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зохион байгуулалт**

- 4.1. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх хугацаа
- 4.2. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

## **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

### **1.1. Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зорилго**

“Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах, эвсэг бүтээлч хамт олныг төлөвшүүлэх, тэднийг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бололцоогоор хангах замаар НБМҮТП-ийн үйл ажиллагааны зорилго, зорилтуудыг бүрэн биелүүлэх, Паркийн үйл ажиллагааг хэвийн, жигд явуулахад уг хөтөлбөрийн зорилго оршино.

### **1.2. Хөтөлбөрийн эрхзүйн үндэс**

Монгол Улсын төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн 33.6 дахь хэсэгт төрийн байгууллага нь төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж ажиллана гэж заасан. Мөн төрийн албан хаагч гэж төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ гэж заасан нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрхзүйн үндэс болж байгаа юм.

### **1.3. Хөтөлбөрийн хэрэгцээ**

Төрийн байгууллагууд ажилчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь тэдний амьжиргааны үндэс болсон цалин хөлсийг нэмэгдүүлэх, ажлын орчин нөхцлийг сайжруулах, ажиллах нөхцөл бололцоогоор хангах, мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх сургалтанд хамруулах, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын зохих хувийг төр хариуцах, үр дүнгийн урамшуулал олгох зэрэг ерөнхий үйл ажиллагаанд чиглэгдэж байна.

Төрийн албан хаагчдын ажиллах нөхцлийг жигд сайжруулж, нийгмийн асуудлыг үнэн зөв, бодит судалгаанд үндэслэн, нээлттэй, ил тод байдлаар шийдвэрлэх нь төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай, үр бүтээмжтэй, идэвх санаачлагатай ажиллах үндсэн нөхцөл болно гэж үзэж байна.

## **ХОЁР. НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА**

### **2.1. Ажилчдын одоогийн нөхцөл байдал**

Нийслэлийн Засаг даргын зохион байгуулалт бүтэц, орон тоо батлах тухай 2014 оны А/1047 дугаар захирамжийг удирдлага болгон тус газрын бүтэц, зохион байгуулалтыг баталсан. НБМҮТП ОНӨТҮГазар 14 албан хаагчтай бөгөөд. Үүнээс: Улс төрийн ажилтан-1, Төрийн үйлчилгээний-13 албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж төр болон аж ахуйн нэгж, байгууллагад үйлчлэн ажиллаж байна.

Албан хаагчдын статистик судалгаа:

- ✓ Нийт албан хаагчдын 84.6 хувь нь өөрийн орон сууцанд, 7.7 хувь нь түрээсийн орон сууцанд, 7.7 хувь нь хувийн хашаа байшинд, монгол гэрт амьдарч байгаа ажилтан байхгүй байна.
- ✓ Ажилчдын 92.3 хувь нь цалингийн болон бусад төрлийн зээлэнд хамрагдсан бөгөөд 7.7 хувь нь зээлгүй байна.

- ✓ Тухайн байгууллагад ажиллаж байгаа ажилласан жилийн хувьд 6 сараас 1 жил хүртэл 20%, 1-5 жил ажиллаж байгаа 80% байна.
- ✓ Хүүхдийн хувьд 69.2 хувь нь 1-2 хүүхэдтэй, 30.8 хувь нь 3-5 хүүхэдтэй, 5-с дээш хүүхэдтэй ажилтан байхгүй, хүүхэдгүй ажилтан мөн байхгүй байна.

## **2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам**

Ажилчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн шууд удирдлага нь газрын дарга байх ба хэрэгжүүлэгч нь Захиргаа, санхүүгийн хэлтэс, Хүний нөөцийн мэргэжилтэн байна. Хөтөлбөрт туссан асуудлаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон бусад салбарын хэмжээний холбогдох эрхийн актад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай бол шинэчлэн боловсруулна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, нөөцийг дайчлах санаачилга гарган, холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

## **2.3. Хэрэгжилтэд тавих хяналт**

Уг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, түүний үр дүнд хяналт тавих ажлыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга хариуцах ба хөтөлбөрийн тайланг улирал тутам гаргах ба жилийн эцэст газрын даргын дэргэдэх Зөвлөлд танилцуулан тайлагнаж, үнэлгээ өгч, үр дүнг хэлэлцэнэ.

## **ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ**

### **3.1. Төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа ба түүний тасралтгүй хөгжлийг хангах**

- ✓ Төрийн албан хаагчдын мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх сургалтад байгууллагын ажилтан, албан хаагчдыг бүрэн хамруулна,
- ✓ Ажилчдын боловсрол, туршлага, хэрэгцээг судлан жил бүр “Сургалт, хөгжлийн төлөвлөгөө боловсруулж ажиллана,
- ✓ Уг салбарт ажиллагсдын зайлшгүй судалсан байх шаардлагатай хууль, тогтоомж, бодлого хөтөлбөрийн жагсаалтыг гаргана,
- ✓ Ажлын байр тус бүрээр судалж, мэргэжлээ дээшлүүлсэн байх шаардлагатай чиглэлийг тогтооно.
- ✓ Уг салбарт ажиллагсдын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг олгох сургалтуудыг зохион байгуулах
- ✓ Гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх, ажил мэргэжлийн холбогдолтой баримт бичгийг англи хэлээр ашиглах чадвартай болгохын тулд бие даан суралцах нөхцлийг бүрдүүлэх, ажлын байран дээр суралцах боломжоор хангана,

- ✓ Өөрийн эрхэлсэн ажлын чиглэлээр дүн шинжилгээ хийх, онол-арга зүйн үндсийг боловсруулах, судалгаа хийх чадавхийг бие даан эзэмших нөхцөл боломжийг бүрдүүлнэ,
- ✓ Эх хэлээ төгс эзэмшиж, ашиглах, бичих, илтгэх ур чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, шаардлагатай сургалтад хамруулна,
- ✓ Эрхэлж буй ажлын чиглэлээр мастер болон докторын сургалтад хамрагдах нөхцөл бололцоог бүрдүүлэх тал дээр анхаарч ажиллана.

### **3.2. Ажилчдын цалин хөлс, урамшууллын уян хатан, ил тод, шударга тогтолцоог бүрдүүлэх**

- ✓ Ажилчдын цалин хөлсийг ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээ, ур чадвар, мэргэшлээс хамааруулан шинэчлэн тогтоож байх,
- ✓ Ажил хавсарсан болон орлон ажиллах тохиолдолд ажлын гүйцэтгэл, хугацаа зэргийг харгалзан үндсэн цалингийн 40 хүртэл хувиар нэмэгдэл хөлс олгох,
- ✓ Байгууллагын захиалгаар урт хугацааны сургалтад хамрагдаж, ажлаас түр чөлөөлөгдсөн ажилчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг зохих хууль тогтоомжийн дагуу төлж, баталгаажуулах, сургалтын дараа тодорхой хугацаагаар байгууллагадаа ажиллах гэрээ байгуулах
- ✓ Албан хаагчийн ажилласан хугацаа, ажлын үр бүтээл, идэвх санаачлагыг харгалзан мөнгөн болон материаллаг урамшууллыг олгож байх,
- ✓ Салбарын шагнал, төрийн одон медальд болзол журмыг нь хангасан албан хаагчдыг тухай бүрт нь тодорхойлж байх.

### **3.3. Ажилчдын хэрэгцээнд үндэслэн орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, нөхцлийг нь сайжруулахад дэмжлэг үзүүлэх**

- ✓ Ажилчдын орон байрны талаар гаргасан өргөдөл, хүсэлтийг ил тод, нээлттэй байлган, шударга шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлэх,
- ✓ Ажилчдыг орон сууцны урт болон богино хугацааны зээлд хамруулахад баталгаа гаргах, хүүгийн хөнгөлөлт үзүүлэх зэргээр дэмжлэг үзүүлэх асуудлыг судалж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх,
- ✓ Хөрөнгө оруулалтаар ажилтан, албан хаагчдад зориулсан нийтийн орон сууц барих асуудлыг судлан шийдвэрлүүлэх,
- ✓ Байгууллагын эзэмшил талбайд байгууллагын дотоод хэрэгцээнд зориулсан ногоо тарих, өрхийн аж ахуй эрхлэх боломжийг судлах, хэрэгжүүлэх.

### **3.4. Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажилчдын нийгмийн баталгааг сайжруулах**

- ✓ Байгууллагын хөдөлмөрийн хууль, дотоод журмын дагуу шаардлагатай ажилчдад нэг удаагийн тусламж дэмжлэгийг үзүүлэх,
- ✓ Албан хаагчдын үр дүнгийн үнэлгээг гэрээний гүйцэтгэл, биелэлтэд тулгуурлан дүгнэж, стратеги зорилтыг ханган ажиллахад оруулсан хувь нэмэр, бүтээлч санаачлага, оролцоог үндэслэн урамшууллыг олгоно.
- ✓ Ажил, амралтын цаг, чөлөө авах, ээлжийн амралт, албан томилот, цалин, шагнал, урамшуулал, тэтгэмж, нөхөн олговор зэргийг олгохтой холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд оновчтой зохион байгуулж ажиллана.
- ✓ Ганц бие, өрх толгойлсон болон шинээр гэр бүл болсон залуу гэр бүлд эд хөрөнгийн болон санхүүгийн тусламж, дэмжлэг үзүүлнэ.
- ✓ Төсвийн цалингийн зардалд багтааж, хоолны мөнгийг Хөдөлмөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг үндэслэн шинэчлэн тогтоож байх.

**3.5. Ажилчдын осол гэмтэлгүй, ая тухтай, бие сэтгэлзүйн ямар нэг дарамт, шахалтгүй ажиллах эерэг таатай орчинг бүрдүүлж, ажлын бүтээмж, гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх**

- ✓ Албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай ажлын нөхцлийг бүрдүүлж, техник хэрэгсэл /өрөө тасалгаа, компьютер, хэвлэгч, хувилагч, ширээ, сандал, бичгийн хэрэгсэл, харилцаа холбооны аппарат гэх мэт/-ээр бүрэн хангах, өрөө тасалгааны тохижилтийг тухай бүр хийх,
- ✓ Ажлын байрны зураг авалт хийж, чиг үүргийг оновчтой тодорхойлох, ажлын ачааллыг жигдрүүлэх, илүү шат дамжлага, давхардлыг арилгах арга хэмжээ авах,
- ✓ Байгууллагын мэдээллийн технологи, дотоод сүлжээний ашиглалтыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх,
- ✓ Албан хаагчдын ээлжийн амралтаа бүрэн эдлэх нөхцөл боломжийг бүрдүүлж, ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх,
- ✓ 3 хүртэлх насны хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэйчүүдийн ажлын цаг, ачааллыг зохицуулах,
- ✓ Ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлэн илүү цагаар ажилласан бол нөхөн амрах, амрах боломжгүй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу илүү цагийн хөлсийг тооцон олгох,
- ✓ Аюулгүй ажиллагааны дүрэм журмыг боловсруулж, чанд мөрдөж ажиллах,
- ✓ Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагчийг хамгаалах арга хэмжээг авах,
- ✓ Ажилчдын ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангах.

### **3.6. Ажилчдыг чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх, хамт олны тааламжтай, сэтгэлзүйн эрүүл орчин бүрдүүлэх**

- ✓ Ажилтан, албан хаагчдыг урьдчилан сэргийлэх, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд жил бүр хамруулах,
- ✓ Бие бялдраа чийрэгжүүлэх танхим, хэрэгсэл, амрах өрөө тасалгааг бий болгон тохижуулах,
- ✓ Байгууллага, хамт олноороо аливаа хорт зуршлаас татгалзан, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх,
- ✓ Байгууллагын ажилчдыг сард нэг ба түүнээс дээш удаа спорт заал болон бусад арга хэрэгслээр биеийн тамир, дасгал хөдөлгөөн хийх боломж нөхцлийг бүрдүүлэх,
- ✓ Амралт болон баяр ёслолын үеэр чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөхөд чиглэсэн арга хэмжээ, уралдаан тэмцээн, үзвэр үйлчилгээ, аялал зугаалга зэрэг нийтийг хамарсан үйл ажиллагааг зөв зохистой зохион байгуулах,
- ✓ Хамт олонч, эвсэг уур амьсгалыг дэмжих, байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн албан болон албан бус уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг зэргийг зохион байгуулах.

## **ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **4.1. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх хугацаа**

Энэхүү хөтөлбөр нь 2019-2023 оны байгууллагын хүний нөөцийн төлөвлөгөө, зорилго, зорилтуудыг бодлогоор хангах бөгөөд 4 жил тутамд шинэчлэн сайжруулж, сүүлийн үеийн чиг хандлагад тохируулан өөрчилнө.

### **4.2 Хөтөлбөрийн хүрэх үр дүн**

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааг хангах, тасралтгүй хөгжих, сурах, ажлынх нь үр дүнг үнэлэн урамшуулах, ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах талаар удирдлагын хариуцлага дээшилж, албан хаагчдаас энэ талаарх шийдвэрийг гаргахад оролцох, хэрэгжүүлэх, хяналт тавих боломж нэмэгдэх юм. Дээрх хөтөлбөрийн үр дүнд:

- ✓ Ажилчдын ажлын байрны сэтгэл ханамж дээшилснээр ажлын бүтээмж сайжирч, тогтвортой ажиллах нөхцөл бололцоо бүрдэнэ.
- ✓ Ажлын байранд сурч хөгжих, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх боломжтой болсноор ажилчдын албан тушаал ахих боломж нэмэгдэнэ.
- ✓ Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах тухай хуулийн заалт байгууллагын хэмжээнд биелэгдэнэ.
- ✓ Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгаа хангагдсанаар ажилчдын ажилдаа хандах хандлага, идэвх санаачлага сайжирна.

- ✓ Хамт олны багаар ажиллах чадвар сайжирч, байгууллагын соёл төлөвшиж, нэг зорилгын дор нэгдсэн бүтээлч хамт олон бий болно.
- ✓ Ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах хүсэл эрмэлзэл нэмэгдснээр хүний нөөцийн эрсдлийн хувь хэмжээ буурна.
- ✓ Ур чадвартай, мэдлэг туршлагатай, сэтгэл ханамжтай хүний нөөц бүрдсэнээр байгууллагын үйл ажиллагааны зорилго, зорилтууд цаг хугацаандаа, бүрэн биелэгдэх боломжоор хангагдана.

----oO----